



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 04 өдөр

Дугаар А/02

Амардалай

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт
шилжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Аймгийн Онцгой комиссын 2024 оны 01 дүгээр хурлын шийдвэр, Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн А/05 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын нийт нутгаар цас орж, өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч болзошгүй байгаатай холбогдуулан сумын хэмжээнд 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс гамшгаас хамгаалах Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2.Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан холбогдох арга хэмжээг авч ажиллахыг сумын Шуурхай штабын дарга (С.Нарантунгалаг)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Л.Золжаргал)-д даалгасугай.

ДАРГА  М.БАЯРСҮХ

